



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/179

Улаанбаатар хот

┌ Арга хэмжээ зохион байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/179, А/923 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Улаанбаатар спорт-2018” бүх нийтийн арга хэмжээг 2018 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсугай.

2. Улаанбаатар спорт-2018” бүх нийтийн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.


3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 10.910.000 /Арван сая есөн зуун арван мянган/ төгрөгийг Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/923 дугаар захирамжаар батлагдсан төсвийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.

4. Улаанбаатар спорт-2018” бүх нийтийн арга хэмжээг урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж хөтөлбөрийн дагуу зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтэс /А.Болдмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД



Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны *10 дугаар* сарын *05*-ны өдрийн
Авт дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

“УЛААНБААТАР СПОРТ-2018” БҮХ НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨСӨВ